



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Гүйцэтгэлийн аудитын тайлан

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ



Бодлогын баримт бичиг нийцээгүй төсөл, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн, гүйцэтгэлийн хяналт, үр дүн хангалтгүй зөрчил дутагдал давтагдсаар байна.

2021 он

АГУУЛГА

<p>Тайланг бэлтгэсэн:</p> <p>Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар</p> <p>Дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа</p> <p>Аудитын менежер Г.Наранбаяр</p> <p>Ахлах аудитор Б.Дарханбат</p> <p>Аудитор С.Батцэцэг</p> <p>2021 оны 05 дугаар сар</p> <p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70543151 дугаарын утсаар харилцана уу.</p> <p>ХАЯГ: Аймгийн Засаг даргын тамгын газрын байр, 2 дугаар давхар, 209 тоот</p>	<p>Товчилсон үгийн тайлбар Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй</p> <p>Бүлэг 1: Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад тооцоо судалгаагүй, бодлогын баримт бичигтэй нийцээгүй, хөрөнгө оруулалтын бус шинж чанартай төсөл, арга хэмжээнүүд батлагдаж төлөвлөлтийн ажил үр дүн муутай байна.</p> <p>1.1 Орон нутгийн дунд хугацаанд баримтлах бодлогын баримт бичгийг үндэслэн орон нутгийн хөрөнгө оруулалтыг төлөвлөөгүй байна..... 6</p> <p>1.2 Зураг төсвийн ажлын даалгаврын 77 хувийг хугацаа алдан боловсруулж он дамжуулснаас магадлалаар баталгаажиж дуусаагүй байна..... 9</p> <p>1.3 Төлөвлөлтийн шаардлага хангаагүй болон хөрөнгө оруулалтын бус шинж чанартай 117,877.0 мянган төгрөгийн 3 төсөл, арга хэмжээ батлагдсан байна. 10</p> <p>..... 12</p> <p>Бүлэг 2 Захиалагч зураг төсвийн ажлыг батлагдсан төсөвт өртгөөр нь бус жижиглэн шууд гэрээ байгуулсан нь ил тод байдал, өрсөлдөөнийг хязгаарласан, зарим ажлын гүйцэтгэгч нар ажлыг чанартай хийгээгүй, захиалагчийн хяналт үр дүнгүй, мэргэжлийн байгууллагаас хяналт шалгалт хийгээгүй нь хөрөнгө оруулалтын үр дүнг бууруулсан байна.</p> <p>2.1 Захиалагч зураг төсвийн ажлыг батлагдсан төсөвт өртгөөр нь бус жижиглэж шууд гэрээ байгуулсан нь ил тод байдал, өрсөлдөөнийг хязгаарласан байна. 12</p> <p>2.2 Зарим ажлын гүйцэтгэгч нь ажлыг чанартай гүйцэтгээгүй ба захиалагчийн хяналт хангалтгүй, мэргэжлийн байгууллагаас хяналт шалгалт хийгээгүй байна..... 14</p> <p>Бүлэг 3 Хөрөнгө оруулалтын үр нөлөөг тооцоогүй, хөрөнгийг ашиглагч байгууллагууд бүртгэж тайлагнаагүй, бүрэн хүчин чадлаар нь ашиглаагүй байна.</p> <p>3.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын зорилтот түвшнийг урьдчилан тооцоогүйгээс гүйцэтгэл болон хүрсэн үр дүнгийн талаар судалгаа хийгдээгүй, ашиглалтад хүлээн авсан хөрөнгө оруулалтын ажлыг ашиглагч байгууллагууд бүртгэж тайлагнаагүй, түүнд хяналт тавиагүй байна..... 18</p> <p>Дүгнэлт Зөвлөмж Холбогдох байгууллагын санал Холбогдох байгууллагын саналд хийсэн тайлбар Хавсралтууд</p>
---	---

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
ЭЗНХҮЧ	Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл
ЗДҮАХ	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТАХ	Төсөл арга хэмжээ
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 05 дугаар тогтоол, “Аудитын төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/28 дугаар тушаал, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу хийлээ.

2. Аудитын зорилт:

Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд Гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.

3. Аудитын хамарсан хүрээ:

2020 онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан 27 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, холбогдох баримт материалуудыг хамрууллаа.

4. Аудитын арга зүй:

Аудитыг АДБОУС (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан. Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS6817-1:2020 “Төрийн аудит Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим, MNS 6817-7:2020 “Төрийн аудит Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам, гүйцэтгэлийн аудит хийх аргачлалыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсрууллаа.

5. Аудит хийх багийн бүрэлдэхүүн:

Аудитыг дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Дарханбат, аудитор С.Батцэцэг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

6. Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл

Аудитын тайлан нь аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, холбогдох байгууллагын санал, түүнд хийсэн тайлбар, хавсралт гэсэн бүтцээр үндсэн зорилтын дагуу бичигдсэн.

7. Хүндрэл бэрхшээл

Ковид-19 цар тахалтай холбоотойгоор хөл хорио тогтоосон нь хүндрэл учруулж байлаа.

8. Үндсэн мэдээлэл

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2020 онд шинээр 1,597,654.2 мянган төгрөгийн 38 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр батлагдсан бөгөөд 1,487,078.5 мянган төгрөгийн гэрээ байгуулсан байна. Үүнээс 80,200.0 мянган төгрөгийн ажлын гэрээ байгуулагдаагүй он дамжиж, 30,380.0 мянган төгрөгийн гэрээний хэмнэлт үүссэн байна.

Аймгийн Орон нутгийн өмчийн газар нь 1,509,377.0 мянган төгрөгийн 31 арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөснөөс 1,486,218.7 мянган төгрөгийн 27 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүргүүлсэн байна.

Хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу нээлттэй тендер шалгаруулалт-6, шууд гэрээ-5, зөвлөх үйлчилгээ-1, харьцуулалтын аргаар 15 худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ.

Ажлын 2, зөвлөх үйлчилгээний 9, бараа үйлчилгээ худалдан авах 1, нийт 12 арга хэмжээ он дамжин хэрэгжсэн байна.

Бүлэг 1

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад тооцоо судалгаагүй, бодлогын баримт бичигтэй нийцээгүй, хөрөнгө оруулалтын бус шинж чанартай төсөл,, арга хэмжээнүүд батлагдаж төлөвлөлтийн ажил үр дүн муутай байна.

1.1 Орон нутгийн дунд хугацаанд баримтлах бодлогын баримт бичгийг үндэслэн орон нутгийн хөрөнгө оруулалтыг төлөвлөөгүй байна.

1.1.1 Захиалагч буюу аймгийн ЗДТГ нь орон нутагт нэн тэргүүнд хэрэгцээ шаардлагатай төсөл арга хэмжээний жагсаалтыг бэлтгээгүй байна.


2020 оны Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасан асуудлыг нэн тэргүүнд шийдвэрлэх зорилгоор аймгийн ОНХС болон албан байгууллагуудаас ирсэн санал хүсэлтийг үндэслэн аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, ИТХ-аар батлуулсан байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр баталсан 20 ажлыг байгууллагын саналаар, 18 ажлыг тодорхой саналд үндэслээгүй байна.

Дүрслэл 1

Байгууллагын саналаар:	Тодорхой саналд үндэслээгүй:
<ol style="list-style-type: none">1. Найрамдал хотхоны бохирын өргөх станцын өргөтгөлийн ажил2. Тохижилтын ажлын хяналтын камер байршуулах3. Цагдаагийн постны авто зогсоолын ажил4. Гомбосүрэн ноёны нэрэмжит талбайн тохижилтын ажил5. Илчлэг Шивээ ОНӨААТҮГазарт зуух зөөж тээвэрлэх, суурилуулах ажил6. Талын Илч ОНӨААТҮГазарт зуух худалдан авч суурилуулах ажил7. Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ-т хог тээвэрлэх автомашин худалдан авах ажил8. Биеийн тамир спортын газрыг шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах9. 100 ортой нэгдсэн эмнэлгийн барилгын ажлыг дуусгаж, шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах10. Цөм сүрэг үржлийн төвд автомашин худалдан авах11. Мэргэшсэн эмч нарын байранд эд зүйлс худалдан авах ажил12. ГХБХБГазарт автомашин худалдан авах ажил13. Аймгийн Засаг даргын тамгын газарт автомашин худалдан авах ажил14. Усан спортын сургалтын төвийн усан бассейны засварын ажилд шаардлагатай бараа материал худалдан авах ажил15. Баянтал сумын 4 дүгээр сургуулийн урлаг заалны их засварын ажлын зураг төсөв16. Халдвартын эмнэлгийн их засварын ажлын зураг төсөв17. Нийтийн номын сангийн барилгын их засварын зураг төсөв18. Боржигин өв музейн барилгын их засварын зураг төсөв19. Хүүхдийн эмнэлгийн их засварын зураг төсөв20. Сүмбэр сумын 1-р сургуулийн өргөтгөлийн барилга	<ol style="list-style-type: none">1.1,2,4 дүгээр багт хийгдэх тоглоомын талбай, тохижилтын ажил2.3 дугаар багийн нийтийн эзэмшлийн талбайн тохижилт /Цэргийн алдрын хөшөө, Сүмбэр гардены хүүхдийн тоглоом/3. Чойр хийдийн дуганы гадна, дотор засварын ажил4. Төрийн байгууллагуудад тоног төхөөрөмж худалдан авах5. Сургууль, цэцэрлэг, номын сангийн фондыг нэмэгдүүлэх зорилгоор ном худалдан авах6. Аймгийн өвс тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэх арга хэмжээний зардал7. Боржигин өв соёлыг түгээх, сурталчилахад зориулж эд зүйлс худалдан авах8. Төрийн архивын хадгалалт, хамгаалалт9. Ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байрны засвар10. Гацуур мод худалдан авах зардал11. Чойр хийдийн гол Дуганы өөрчлөлтийн зураг төсөв12. Сүмбэр сумын 2 дугаар багийн тоглоомын талбайн зураг төсөв13. Төсөв шинэчлэх14. Сүмбэр сумын 1-р багт дахин төлөвлөлт хэрэгжүүлэх байршилд ерөнхий төлөвлөгөөний зураг15. Өмчлөлд олгосон газарт цахилгаан татах ажлын зураг төсөв16. Аймгийн тэжээлийн нөөц бүрдүүлэх17. Аймгийн өвсний нөөц бүрдүүлэх18. Аймгийн төвийн гэрэлтүүлэг


ОНТХО-ын 2019 болон 2020 онд батлагдсан төсвийн хэмжээг харьцуулан графикаар харуулбал:



Графикаас харахад: Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын дүн 2019 онд 482,312.2 мянган төгрөг байсан бол 2020 онд 1,663,950.4 мянган төгрөг болж 3.5 дахин нэмэгджээ.

2020 онд шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын 1,259,500.0 мянган төгрөгийн 19 ажлыг аймгийн ИТХ-ын 2019.11.29-ний өдрийн №09 дүгээр тогтоолоор баталсан ба 2020.09.18-ны өдрийн № 08 дугаар тогтоолоор 8 ажлын 338,161.2 мянган төгрөгийн хөрөнгийг нэмж баталсан байна.

Шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын ажлын задаргааг графикаар харуулбал:



Графикаас харахад: 2020 онд Шинээр хэрэгжихээр батлагдсан төсөл арга хэмжээний 442,000.0 мянган төгрөг буюу 27.6 хувь нь тохижилтын ажил, 400,284.2 мянган төгрөг буюу 25.0 хувь нь өргөтгөл, засварын ажил, 284,500.0 мянган төгрөг буюу 17.8 хувь нь автомашин худалдан авах, 226,887.0 мянган төгрөг буюу 14.2 хувь нь тоног төхөөрөмж бараа материал худалдан авах, 150,000.0 мянга буюу 9.4 хувь нь зураг төсөв, 95,000.0 мянган төгрөг буюу 5.9 хувийг өвс тэжээлийн нөөц бэлтгэх ажил тус тус эзэлжээ.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын 11% хувь нь улсын төсвийн байгууллагуудад чиглэсэн байна.

Тайлант хугацаанд орон нутагт нэн тэргүүнд хэрэгцээ шаардлагатай байгаа төсөл, арга хэмжээний жагсаалтыг бэлтгээгүй байна.

1.1.2 Хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ нь аймгийн Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт бүрэн нийцэж чадаагүй байна.

Аудитаар Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээ нь аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, ЭЗНХҮЧ-д нийцэж буй эсэхийг тулгахад дараах байдалтай байна. /Дэлгэрэнгүй жагсаалтыг хавсралт №1-ээс харна уу/

Хүснэгт №1

Батлагдсан төсөл, арга хэмжээний тоо	Засаг даргын 2016-2020 үйл ажиллагааны хөтөлбөр		Аймгийн Эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл	
	Нийцсэн	Нийцээгүй	Нийцсэн	Нийцээгүй
38	10	28	27	11

Хүснэгтээс харахад: 2020 оны орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан 38 ^{11 төсвийн задаргаа орсон} төсөл, арга хэмжээнээс Аймгийн ЗДҮАХ-т 28 буюу 73.6 хувь, ЭЗНХҮЧ-д 11 буюу 28.9 хувь нь тус тус нийцээгүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 6 дугаар зүйлийн 6.4.2-т “тухайн жилийн хөрөнгө оруулалтын бодлогын чиглэл болон үндсэн чиглэлтэй нийцэж буй байдал” гэж заасныг зөрчсөн байна.

Цаашид аймгийн хэмжээнд хөрөнгө оруулалтаар хийгдэх шаардлагатай ажлын жагсаалтыг гаргаж, ач холбогдлоор нь эрэмбэлж, дунд хугацааны бодлогын бичиг баримтуудтай уялдуулан төсөл, арга хэмжээний үр ашиг, үр нөлөөг тооцож төлөвлөх тухай зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

1.1.3 Орон нутгийн хөрөнгө оруулалтын 33.6 хувь нь иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад чиглэжээ.

Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан орон нутгийн иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн 7 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

Дүрслэл №2



ОНХО-аар 2020 онд хэрэгжүүлэхээр баталсан 1,597,654.2 мянган төгрөгийн 38 төсөл, арга хэмжээнээс 33.6 хувь буюу 538,000.0 мянган төгрөгийн арга хэмжээ нь иргэдийн эрүүл аюулгүй орчинд аж төрөх хэрэгцээ шаардлагыг хангахад чиглэжээ.

1.2 Зураг төсвийн ажлын даалгаврын 77 хувийг хугацаа алдан боловсруулж он дамжуулснаас магадлалаар баталгаажиж дуусаагүй байна.

1.2.1 Барилга, байгууламжийн зураг төсөл зохиох ажлын даалгаврыг салбарын бодлого, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлага, геологийн дүгнэлт, техникийн нөхцөлүүд, газрын зөвшөөрөл зэрэгт үндэслэж, зохистой, иж бүрэн боловсруулсан байна.

Аймгийн ИТХ-ын 2019 оны 09 дүгээр тогтоолын 03 дугаар хавсралтаар 2021 онд хийгдэх ажлуудын зураг төсвийн зардалд 150,000.0 мянган төгрөг баталсан бөгөөд аймгийн Засаг даргын 2020 оны А/37 дугаар захирамжаар 11 ажлын зураг төсвийн задаргааг баталжээ.

Эдгээр зураг төсвийн ажлын даалгаврыг салбарын болон хэрэглэгчийн хэрэгцээ шаардлага, бусад шаардлагатай нөхцөлийн дагуу боловсруулж батлуулсан байна. /Дэлгэрэнгүйг ажлын баримт-1-д харуулав./

Харин зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулсан 4, шууд гэрээ байгуулсан 7, нийт 11 зураг төслийн ажлаас 9 нь он дамжсан бөгөөд ажлын даалгавар нь цаг хугацаа алдаж батлагдсантай холбоотой байна.

Ажлын даалгавар батлагдсан болон тендер зарласан хугацааг хүснэгтээр харуулбал:
Хүснэгт №2

№	Төсөл, арга хэмжээний нэр	АИТХ-ын тогтоолын огноо	Засаг даргын захирамжийн огноо	Ажлын даалгавар батлагдсан огноо	Тогтоол батлагдсанаас хойш алдсан хугацаа/хоног/	Захирамж батлагдсанаас хойш алдсан хугацаа/хоног/
1	Сүмбэр сумын 1-р багт дахин төлөвлөлт хэрэгжүүлэх байршилд ерөнхий төлөвлөгөөний зураг			2020.11.13	349	285
2	Халдвартын эмнэлгийн их засварын ажлын зураг төсөв	2019.11.29	2020.02.03	2020.10.12	316	254
3	Өмчлөлд олгосон газарт цахилгаан татах ажлын зураг төсөв /Тэрэгт, Бурхант/			2020.11.13	349	285
4	Сүмбэр сумын 1-р сургуулийн өргөтгөлийн барилга			2020.11.10	346	282

Хүснэгтээс харахад: Аймгийн ИТХ-ын тогтоолоор төсөв батлагдсанаас хойш 316-349 хоног, Засаг даргын захирамжаар ажлын задаргааг баталснаас хойш 254-285 хоногийн дараа тендер зарлагдсан байна.

Үүнээс шалтгаалж 2021 онд хийгдэх хөрөнгө оруулалтын ажлууд хугацаа алдах, төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ аймгийн ИТХ-аар батлагдах нөхцөл байдал үүссэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т “**өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах**”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.5.-т “**энэ хуулийн 7.6-д зааснаас бусад бараа, ажил, үйлчилгээг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэр батлагдсаны дараа худалдан авах ажиллагааг эхлүүлэх**”, 46.1.8.-т “**барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг тухайн жилийн төсөв батлагдсан даруйд эхлүүлэх**”, Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4-т “**Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн багцад тухайн жилд батлагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангаж ажиллана**.” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд аймгийн ИТХ-аар төсөв батлуулахдаа зураг төсвийн задаргааг хамтад нь батлуулах, зураг төсвийн ажлын даалгаврыг тухайн жилийн төсөв батлагдсан даруй боловсруулж, худалдан авах ажиллагааг эхлүүлэх, зөвлөмжийг захиалагч буюу аймгийн ЗДТГ-т хүргүүлэхээр шийдвэрлэв.

1.2.2 Барилга, байгууламжийн зураг төсөв зохиох зардлыг зохиогчийн бодит гүйцэтгэлд үндэслэж шилжүүлсэн байна.

2020 онд 50,600.0 мянган төгрөгийн 6 ажлын зураг төсвийн гэрээг байгуулж, 34,453.0 мянган төгрөгийн санхүүжилтийг зохиогчид олгожээ. Үүнээс 17,953.0 мянган төгрөгийн 2 ажлын зураг төсвийг хүлээн авч санхүүжилтийг олгосон бол 4 ажлын зураг төсвийн гэрээний дагуу 50 хувийн урьдчилгаа санхүүжилтэд 16,500.0 мянган төгрөгийг олгосон байна.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 03 дугаар тогтоолоор гүйцэтгэгч шалгараагүй буюу он дамжсан зураг төсвийн ажлын санхүүжилт 115,547.0 мянган төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлжээ.

1.2.3 Барилга, байгууламжийн зураг төслийг холбогдох хууль тогтоомж, барилгын норм дүрэм, төсвийн үнэ бүрдэл болон төсөв зохиох дүрмийн дагуу магадлалаар баталгаажуулсан байна.

Тайлант онд хүлээн авсан 2 зураг төсвийн ажлаас “Баяр мега сервис” ХХК-ийн гүйцэтгэсэн “Баянтал сумын 4-р сургуулийн урлаг заалны их засварын ажлын зураг төсөв”-ийг магадлалаар баталгаажуулсан байна.

Харин “Эн эй ии” ХХК-ийн гүйцэтгэсэн “Чойрын хийдийн гол Дуганы өөрчлөлтийн зураг төсөв”-ийн ажил магадлалын баталгаа хийлгээгүй бөгөөд өөрчлөлтийн зураг хийгдсэн тул магадал хийлгэх шаардлагагүй гэж үзсэнтэй холбоотой байна.

1.3 Төлөвлөлтийн шаардлага хангаагүй болон хөрөнгө оруулалтын бус шинж чанартай 117,877.0 мянган төгрөгийн 3 төсөл, арга хэмжээ батлагдсан байна.

1.3.1 Төсөл, арга хэмжээ нь төлөвлөлтийн шаардлагыг бүрэн хангаагүй байна.

Аймгийн ИТХ-ын 2019 оны 09 дүгээр тогтоол, 2020 оны 08 дугаар тогтоолоор батлагдсан 38 төсөл арга хэмжээг /11 зураг төсвийн задаргаа орсон/ төлөвлөлтийн шаардлагыг хангасан эсэхийг тулган баталгаажуулахад дараах нийтлэг алдаа, зөрчил илэрлээ. Үүнд:

1. Аймгийн тухайн жилийн бодлого, үндсэн чиглэлтэй нийцээгүй.
2. Байгууллагын санал болон орон нутгийн хэрэгцээ шаардлагад үндэслээгүй.
3. Батлагдсан зураг төсөвгүй ажлыг АИТХ-аар хэлэлцүүлж баталсан.

АИТХ-аар төсөв батлагдсанаас хойш зураг төслийг боловсруулсан болон зураг төсөвгүй ТАХ-ний жагсаалтыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №3

/мянган төгрөгөөр/

№	ТАХ-ний нэр	Тогтоолоор батлагдсан төсөвт өртөг	Зураг, төсөл боловсруулсан эсэх	Магадлалын дүгнэлттэй эсэх	Тайлбар
1	Чойр хийдийн дуганы гадна, дотор засварын ажил	80,000.0	Тийм	Үгүй	Гүйцэтгэгчээр зураг төсвийг боловсруулсан.
2	Гомбосүрэн ноёны нэрэмжит талбайн тохижилтын ажил	72,000.0	Үгүй	Үгүй	Зураг төсөвгүй. Загвар зурагт үндэслэсэн.
3	Тохижилтын ажлын хяналтын камер байршуулах ажил	30,000.0	Үгүй	Үгүй	Зураг төсөвгүй.
4	1,2,4 дүгээр багт хийгдэх тоглоомын талбай, тохижилтын ажил	180,000.0	Үгүй	Үгүй	Зураг төсөвгүй.

5	3 дугаар багийн нийтийн эзэмшлийн талбайн тохижилт /Цэргийн алдрын хөшөө, Сүмбэр гардены хүүхдийн тоглоом/	150,000.0	Үгүй	Үгүй	Загвар зураг болон хэсэгчилсэн зургаар гүйцэтгэсэн.
6	Илчлэг Шивээ ОНӨААТҮГГазарт зуух зөөж тээвэрлэх, суурилуулах ажил	80,000.0	Үгүй	Үгүй	Зураг төсөвгүй.
7	Цагдаагийн постны авто зогсоолын ажил	40,000.0	Үгүй	Үгүй	Зураг төсөвгүй. Загвар зурагт үндэслэсэн.
Нийт		632,000.0			

Хүснэгтээс харахад: 632,000.0 мянган төгрөг буюу хөрөнгө оруулалтын ажлын 62.0 хувь нь зураг төсөвгүй болон загвар зурагт үндэслэн батлуулсан байна. Үүнээс: хөрөнгө оруулалтын ажлын 11 хувийг улсын төсвийн байгууллагуудад хийсэн хөрөнгө оруулалт эзэлж байна.

Төрийн байгууллагуудад тоног төхөөрөмж худалдан авах ажлыг төлөвлөхдөө орон нутгийн байгууллагуудаас шаардлагатай хөрөнгийн судалгааны саналыг аваагүй, ямар байгууллагад хэдэн компьютер, тоног төхөөрөмж шаардлагатай байгаа нь тодорхойгүй, тооцоо, судалгаанд бүрэн үндэслээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т **“төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”** 14 дүгээр зүйлийн 14.2.3-т **“өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”**, 24 дүгээр зүйлийн 24.6-д **“Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ холбогдох норм, норматив, батлагдсан стандарт, зураг төсвийг үндэслэнэ”**, Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.3,-т **“барилга байгууламжийн техникийн нөхцөл, зураг төсөл боловсруулах, барилгын ажлын зөвшөөрлийг энэ хуулийн 22, 23, 26 дугаар зүйлд заасны дагуу авч, түүнд заасан нөхцөлийг биелүүлэх”**, Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан **“Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Бодлогын баримт бичигт тусгагдсан байдал”, “тухайн жилийн хөрөнгө оруулалтын бодлогын чиглэл болон үндсэн чиглэлтэй нийцэж буй байдал”, 7 дугаар зүйлийн 7.2.2 “барилга байгууламжийн хувьд сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалаар баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй байх”, 7.3-д “холбогдох материал, нотлох баримтаар баталгаажсан төлөвлөлт зорилтод нийцсэн, хэрэгцээ шаардлагад тулгуурласан байх”** гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг төлөвлөхгүй байх зөвлөмжийг аймгийн ЗДТГ-т хүргүүлэхээр шийдвэрлэв.

1.3.2 Хөрөнгө оруулалтын бус шинж чанартай төсөл, арга хэмжээг төлөвлөж АИТХ-аар батлуулсан байна.

Аймгийн ИТХ-ын 2019 оны 09 болон 2020 оны 08 дугаар тогтоолоор батлагдсан нийт 117,877.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 3 төсөл, арга хэмжээний зарим ажлууд нь урсгал зардлын шинж чанартай буюу хөрөнгө оруулалтын бус шинж чанартай ажлууд байна.

Хөрөнгө оруулалтын бус шинж чанартай ТАХ-г хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 4

№	ТАХ-ний нэр	Төсөвт өртөг
1	Боржигин өв соёлыг түгээх, сурталчлахад зориулж эд зүйлс худалдан авах	12,877.00
2	Гацуур мод худалдан авах	10,000.00
3	Аймгийн өвс тэжээлийн аюулгүйн нөөц бэлтгэх	95,000.00
Нийт		117,877.00

Мөн 60,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий “төрийн байгууллагуудад тоног төхөөрөмж худалдан авах” ажлаас захиалагч буюу аймгийн ЗДТГ нь 9,542.5 мянган төгрөгийн 5 ширхэг компьютер, 1 ширхэг принтерийг авч байгууллагын урсгал зардлыг санхүүжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24-т “хөрөнгө оруулалт” гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг”, 6 дугаар зүйлийн 6.4.1-т “**төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах**” 14 дүгээр зүйлийн 14.2.3-т “**өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах**” гэж заасныг зөрчсөн тул алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байна уу?

Бүлэг 2

Захиалагч зураг төсвийн ажлыг батлагдсан төсөвт өртгөөр нь бус жижиглэн шууд гэрээ байгуулсан нь ил тод байдал, өрсөлдөөнийг хязгаарласан, зарим ажлын гүйцэтгэгч нар ажлыг чанартай хийгээгүй, захиалагчийн хяналт үр дүнгүй, мэргэжлийн байгууллагаас хяналт шалгалт хийгээгүй нь хөрөнгө оруулалтын үр дүнг бууруулсан байна.

2.1 Захиалагч зураг төсвийн ажлыг батлагдсан төсөвт өртгөөр нь бус жижиглэж шууд гэрээ байгуулсан нь ил тод байдал, өрсөлдөөнийг хязгаарласан байна.

2.1.1 Үнэлгээний хороо хууль журамд заасны дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Аймгийн Засаг даргын захирамжаар 2020 оны “Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт”-аар хэрэгжүүлэх 24 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны гишүүдийг тухай бүр томилжээ.

Давхардсан тоогоор 135 төрийн албан хаагч болон хөндлөнгийн төлөөллийг оролцуулан үнэлгээний хороог байгуулсан бөгөөд үнэлгээний хорооны гишүүд нь худалдан авах ажиллагааны АЗ эрхийн гэрчилгээтэй энэ чиглэлээр сургалтад хамрагдаж мэргэшсэн байна.

Аймгийн Орон нутгийн өмчийн алба нь аймгийн Засаг дарга буюу ТЕЗ-аас баталсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан 31 төсөл, арга хэмжээнээс 27 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны 01 сарын 07-ны А/11 дүгээр захирамжаар “Сүмбэр сумын 1.2.4 дүгээр багт хийгдэх тоглоомын талбай, тохижилтын ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороонд хөндлөнгийн төлөөллөөр орсон иргэн нь үнэлгээний хороонд ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргаагүй, үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлүүдэд гарын үсэг зурж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.8-д “**Үнэлгээний дүгнэлтэд хорооны бүх гишүүд гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд эсрэг саналтай байсан гишүүн үнэлгээний дүгнэлтэд энэ тухайгаа тэмдэглэж гарын үсгээ зурна.**”, Сангийн сайдын 2015 оны 330 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын “**Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг**” хэсгийг тус тус зөрчсөн байна.

Иймд үнэлгээний хороо нь холбогдох хууль, тогтоомж, журам, заавруудын дагуу баримт бичгийг тухай бүр үйлдэж баталгаажуулж ажиллах зөвлөмжийг Орон нутгийн өмчийн газарт өгөхөөр шийдвэрлэв.


2.1.2 Сүмбэр сумын 1, 2, 4 дүгээр багт хийгдэх тохижилтын ажлын тендерийн баримт бичигт 4 дүгээр багт хийгдэх ажлын тоо хэмжээг тусгаагүй, хөрөнгө оруулалтын ажлын зураг төсвийг батлагдсан дүнгээр багцалж худалдан авах ажиллагааг явуулаагүй байна.

Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан үнэлгээний хороо нь 24 төсөл, арга хэмжээг Сангийн сайдын баталсан жишиг баримт бичгийн дагуу тендерийн баримт бичгийг

боловсруулж, захиалагчаар батлуулж ажилласан бол 7 төсөл, арга хэмжээг шууд гэрээ байгуулсан байна.

Тендер шалгаруулалтыг графикаар харуулбал:

График №3



Графикаас харахад: Нийт 31 төсөл арга хэмжээнээс 4 буюу 13 хувь нь зөвлөх үйлчилгээ, 6 буюу 19 хувь нь нээлттэй тендер, 14 буюу 45 хувь нь харьцуулалт, 7 буюу 23 хувь нь шууд гэрээ байгуулсан байна.

Аймгийн ИТХ-ын 2019 оны 09 дүгээр тогтоолын 03 дугаар хавсралтаар 2021 онд хийгдэх ажлуудын зураг төсвийн зардалд 150,000.0 мянган төгрөг баталсан боловч худалдан авах ажиллагааг батлагдсан төсвийн дүнгээр зарлаагүй байна.

11 ажлын зураг төсвийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа 4 ажлын зураг төсвийг зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах журмаар тендер шалгаруулалтыг зохион байгуулж, 7 ажлын зураг төсвийг 53,753.0 мянган төгрөг буюу нийт төсөвт өртгийн 35.8 хувьд шууд гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн байна.

Үүнд: Засаг даргын захирамжаар баталсан орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын жагсаалтын дагуу захиалагчийн зүгээс ажлын даалгаврыг боловсруулаагүй багцын нийт дүнгээр тендер зарлуулахаар Орон нутгийн өмчийн газарт ирүүлээгүй зэрэг нь нөлөөлжээ.

Мөн үнэлгээний хороо нь тендерийн баримт бичгийг боловсруулахдаа “Сүмбэр сумын 1, 2, 4 дүгээр багийн тохижилтын ажил”-ын техникийн тодорхойлолтод 4 дүгээр багт хийгдэх ажлын тоо хэмжээг тусгаагүй байхад энэ талаар захиалагчтай зөвшилцөөгүй, тендерийн баримт бичигт ажлын тоо хэмжээг бүрэн тусгаагүй байна.

Эдгээр нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т **“Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно.”**, 8.5-д **“Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно.”**, **“8.7.1.тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо бүх багцын нийлбэр өртгийг үндэслэл болгох;”**, 47 дугаар зүйлийн 47 дугаар зүйлийн 47.2.1-т **“техникийн тодорхойлолт бэлтгэх, тендерийн урилга, тендерийн баримт бичгийг боловсруулах, тендер хүлээн авах, тендер нээх ажиллагааг холбогдох зааврын дагуу гүйцэтгэх”** Сангийн сайдын 2014 оны 212 дугаар тушаалаар батлагдсан “үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1-т **“Тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолт боловсруулахдаа захиалагчийн шаардлагыг бүрэн хангасан, өрсөлдөөнийг дэмжсэн, хууль тогтоомжид нийцсэн байх зарчмыг баримтална”** гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд тендерийн баримт бичгийг хуульд журамд заасны дагуу иж бүрэн боловсруулах зөвлөмжийг аймгийн Орон нутгийн өмчийн газарт, хөрөнгө оруулалтын ажлын зураг төсвийг батлагдсан төсвийн нийт дүнгээр багцлан зарлаж байх албан шаардлагыг захиалагч буюу аймгийн ЗДТГ-т өгөхөөр шийдвэрлэв.

2.1.3 Орон нутгийн өмчийн алба нь гүйцэтгэгчийг ил тод нээлттэй өрсөлдөх боломжоор хангаж, ХАА-г зохион байгуулсан боловч захиалагчийн зүгээс зураг төсвийн ажлыг батлагдсан дүнгээр багц болгон тендер шалгаруулалт явуулалгүйгээр жижиглэж шууд гэрээ байгуулсан нь ил тод байдал, өрсөлдөөнийг хязгаарласан байна.


Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 24 төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтыг аймгийн ОНӨГ-аас цахимаар зарлаж, тендер шалгаруулалтын үр дүнг цахим хуудсанд нийтэлсэн байна.

Харин захиалагч 53,800.0 мянган төгрөгийн 7 төсөл, арга хэмжээг уламжлалт аргаар буюу шууд гэрээ байгуулжээ.

Шууд гэрээ байгуулсан 7 төсөл, арга хэмжээг графикаар харуулбал:

График № 4

/мянган төгрөгөөр/



Графикаас харахад: Зураг төсвийн 7 ажлыг гүйцэтгүүлэхээр шууд гэрээ байгуулсан бөгөөд үүнээс тайлант онд 19,000.0 мянган төгрөгийн 2 ажлыг хүлээн авсан бол бусад нь он дамжсан байна.

Захиалагч нь шууд гэрээ байгуулсан төсөл, арга хэмжээний гэрээний хувийг үндэслэлийн хамт Сангийн яаманд хүргүүлэх үүргээ биелүүлээгүй, Зураг төсвийн ажлыг батлагдсан төсвийн дүнгээр тендер шалгаруулалт явуулахгүйгээр жижиглэн шууд гэрээ байгуулж байгаа нь ашиг сонирхлын зөрчил үүсэх, ил тод байдлыг хангахгүй байх, өрсөлдөөнийг хязгаарлах үр дагавартай байна.

Орон нутгийн өмчийн албанаас зохион байгуулсан худалдан авах ажиллагаатай холбоотой 2 гомдол гарсныг Сангийн ямаар хянуулж захиалагч, үнэлгээний хорооны шийдвэрийг үндэслэлтэй гэж үзжээ.

2.2 Зарим ажлын гүйцэтгэгч нь ажлыг чанартай гүйцэтгээгүй ба захиалагчийн хяналт хангалтгүй, мэргэжлийн байгууллагаас хяналт шалгалт хийгээгүй байна.

2.2.1 Захиалагч гэрээг холбогдох хууль журмын дагуу байгуулсан ба гэрээний хэрэгжилтийг дунджаар 87.3%-тай гэж дүгнэсэн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд хэрэгжүүлэхээр батлагдсан нийт 1,597,654.2 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 38 төсөл, арга хэмжээнээс /зураг төсвийн задаргаа 11 ажил багтсан/ 26 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжсэн бөгөөд 12 төсөл, арга хэмжээ он дамжсан байна.

Тухайлбал: нийт 111,500.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 9 зураг төсөв, 60,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий “Талын илч ОНӨААТҮГ-т уурын зуух худалдан авч суурилуулах ажил”, 80,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий “Чойрын хийдийн дуганы гадна, дотор засварын ажил”, 85,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Аймгийн Засаг даргын тамгын газарт автомашин худалдан авах” ажлууд он дамжсан байна.

Тайлант онд хэрэгжиж дуусаагүй он дамжсан ажлыг харуулбал:

Он дамжсан төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртгийн дүн
Аймгийн Засаг даргын тамгын газарт автомашин худалдан авах	85,000.00

ОНЕО-д үлдэгдлээр төвлөрүүлсэн.	
Зураг төсөв боловсруулах ажил	111,500.00
ОНЕО-д үлдэгдлээр төвлөрүүлсэн.	
Талын илч ОНӨААТҮГ-т уурын зуух худалдан авч суурилуулах ажил	60,000.00
30,000 мянган төгрөгийг барьцаа дансанд төвлөрүүлсэн.	
Чойр хийдийн дуганы гадна, дотор засварын ажил	80,000.00
55,754.4 мянган төгрөгийн санхүүжилт олгож 24,159.2 мянган төгрөгийг барьцаа дансанд байршуулсан.	
Нийт	336,500.00

Хүснэгтээс харахад: нийт 196,500.0 мянган төгрөгийн “Зураг төсөв” болон “Аймгийн ЗДТГ-т автомашин худалдан авах” ажлыг аймгийн ИТХ-ын 2020 оны 03 дугаар тогтоолоор дараа онд шилжүүлж, “Чойр хийдийн дуганы гадна, дотор засварын ажил”-ын үлдэгдэл санхүүжилт 24,159.2 мянга, “Талын илч ОНӨААТҮГ-т уурын зуух худалдан авч суурилуулах ажил”-ын үлдэгдэл санхүүжилт 30,000.0 мянга, нийт 54,159.2 мянган төгрөгийг барьцаа дансанд төвлөрүүлжээ.

Захиалагч нь 2020 онд хэрэгжиж, ашиглалтад хүлээн авсан төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй нартай байгуулсан гэрээний хэрэгжилтийг дүгнэж ажилласан бөгөөд хэрэгжилт дунджаар 87.3 хувьтай байна.

2.2.2 Зарим ажлыг гэрээний хугацаанд чанартай гүйцэтгээгүй байна.

Аудитын явцад 17 төсөл, арга хэмжээний ажлын чанар, ашиглалтын шаардлага хангасан эсэхийг шалгахад ашиглалтын болон чанарын шаардлага хангаагүй дараах зөрчил илэрлээ.

1. “Сүмбэр сумын Найрамдал хотхоны бохирын өргөх станцын өргөтгөлийн ажил”-ын гүйцэтгэгч “Илчит сансар” ХХК нь уг ажлыг захиалагчаас өгсөн даалгавар тоо хэмжээний дагуу хийсэн боловч технологийн шийдэл болон ашиглагч байгууллагын үйл ажиллагаанаас шалтгаалан эвдрэл гэмтэл гарсан.
2. “Илчлэг Шивээ” ОНӨААТҮГ-т зуух зөөж тээвэрлэх, суурилуулах ажил”-ын гүйцэтгэгч “Жавхлант арвижих” ХХК цахилгааны ажлыг чанаргүй гүйцэтгэснээс шалтгаалж холболтууд шатаж цахилгаан хэрэгслүүд эвдэрч гэмтсэн байна.

Мөн “Чойр хийдийн дуганы гадна, дотор засварын ажил”-ын гүйцэтгэгч болон захиалагчийн хооронд байгуулсан ГСАОНӨГ/202009026 тоот гэрээнд зааснаар засварын ажлыг 2020 оны 10 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн 2020 оны 11 дүгээр сарын 08-ны хооронд гүйцэтгэх хугацаатай байсан боловч одоог хүртэл бүрэн хийгдээгүй бөгөөд гэрээний сунгалт хийгээгүй ажлыг гүйцэтгэх хугацаа дууссан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т **“төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”** 14 дүгээр зүйлийн 14.2.3-т **“өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”**, Иргэний хуулийн 350 дугаар зүйл 350.1.1-т **“гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэх”**, 350.1.6-д **“захиалагчийн өмчлөлд ямар нэгэн доголдолгүй үр дүн шилжүүлэх”**, 351 дүгээр зүйлийн 351.1.2-т **“гүйцэтгэсэн ажлын үр дүнг хугацаанд нь хүлээн авах”**, 351.1.4-т **“ажил гүйцэтгэгчийн тавьсан шаардлагын дагуу чанар муутай буюу шаардлага хангахгүй материалыг сольж өгөх, буруу зааварчилгаагаа өөрчлөх, ажлын чанар, үр дүнд муугаар нөлөөлөх бусад нөхцөл байдлыг арилгах талаар өөрөөс шалтгаалах бүхий л арга хэмжээ авах.”** гэсэн заалтууд болон гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний холбогдох зүйл заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Цаашид чанаргүй хийсэн ажлыг дахин хийлгэх, эвдрэл гэмтэл гарсан ажлуудын технологийн шийдлийг оновчтой гаргаж ашиглалтын хэвийн нөхцөлд оруулах, гэрээний хугацаанд ажлыг бүрэн гүйцэтгүүлэх тухай албан шаардлагыг захиалагч буюу аймгийн ЗДТГ-т өгөхөөр шийдвэрлэв.

2.2.3 ТАХ-ний санхүүжилтийг үндэслэлтэй тооцож олгосон байна.

Аймгийн ИТХ-ын 2019 оны 09 дүгээр тогтоолоор шилжих хөрөнгө оруулалтыг 66,289.2 мянга, шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын ажилд 780,000.0 мянга, тоног төхөөрөмж худалдан авах ажилд 479,500.0 мянга, 2020 оны 08 дугаар тогтоолоор шинээр эхлэх хөрөнгө оруулалт, засварын ажилд 241,284.2 мянга, тоног төхөөрөмж худалдан авах ажилд 31,877.0 мянга, өвс тэжээл худалдан авахад 65,000.0 мянга, нийт 1,663,950.4 мянган төгрөгийн эх үүсвэрийг баталсан байна.

Тайлант хугацаанд 35 төсөл арга хэмжээнд 1,487,078.5 мянган төгрөгийн гэрээ байгуулсан байна.

2020 онд гэрээ байгуулсан ажлын санхүүжилтэд 1,360,351.9 мянга, өмнөх оноос дамжсан ажлын санхүүжилтэд 70,201.8 мянга, нийт 1,430,553.7 мянган төгрөгийг санхүүжилт болон барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлжээ.

Он дамжсан ажлын үлдэгдэл болон гэрээний хэмнэлтийн 233,396.6 мянган төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн бөгөөд үүнээс гэрээний хэмнэлт 30,375.6 мянга, он дамжсан ажлын үлдэгдэл санхүүжилт 203,021.0 мянган төгрөг байна.

Захиалагч нь орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтийг үндэслэлтэй тооцож олгосон байна.

2.2.4 Захиалагчаас тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Говьсүмбэр аймагт 2020 онд хийгдэх барилга байгууламж, барилгын засварын ажилд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх гэрээг аймгийн ЗДТГ болон ГХБХБГ-ын хооронд байгуулсан байна.

Гэрээний хавсралтаар орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 592,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 5 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хийхээр баталсан боловч 4 төсөл, арга хэмжээнд хяналт тавьсан тайланг аудитад хамрууллаа.

Захиалагчийн хяналтыг гэрээгээр хэрэгжүүлсэн аймгийн ГХБХБГ-ын хяналтын тайланг тоймлож үзвэл:

Хүснэгт № 5

№	ТАХ-ний нэр	Гүйцэтгэгч	Захиалагчийн хяналтаар илэрсэн асуудал
1	3 дугаар багийн нийтийн эзэмшлийн талбайн тохижилт /Цэргийн алдрын хөшөө, Сүмбэр гардены хүүхдийн тоглоом/	Чинбат ХХК	Гүйцэтгэгч захиалагчаас өгсөн ажлын даалгавар, загвар зургийн дагуу ажлыг гүйцэтгэсэн.
2	Найрамдал хотхоны бохирын өргөх станцын өргөтгөлийн ажил	"Илчит сансар" ХХК	Хуучин бохирын өргөх станцаас бохир алдагдаж байсан тул ажлыг гүйцэтгэх явцад хүндрэл учирч бохир усыг насосоор соруулж зайлуулсан. Ажлын гүйцэтгэх явцад зураг төсөвт өөрчлөлт оруулсан бөгөөд энэ талаар зохиогчтой зөвшилцсөн.
3	Гомбосүрэн ноёны нэрэмжит талбайн тохижилтын ажил	"Энержи сет" ХХК	Захиалагчийн хүсэлтээр гадна хашааны загвар, усалгааны систем, цэвэр усны эх үүсвэр зэрэгт өөрчлөлт оруулсан. Ажлын тоо хэмжээнд хашааны урт дутуу байсныг магадлашгүй ажлын зардлаар хийсэн.
4	1, 2, 4 дүгээр багт хийгдэх тоглоомын талбай, тохижилтын ажил	"Чинбат" ХХК	Ажлыг захиалагчаас өгсөн ажлын даалгаврын дагуу хийж гүйцэтгэсэн. Сүмбэр сумын 4-р багийн төвд хийх ажил тоо хэмжээнд тусгагдаагүй боловч гүйцэтгэгч байгууллага өөрсдийн боломжоор тайзны суурь хийсэн.

Эх сурвалж: аймгийн ГХБХБГ-ын захиалагчийн хяналтын тайлан

Хүснэгтээс харахад: Захиалагчтай байгуулсан гэрээнд заасан 5 төсөл, арга хэмжээнээс 4 төсөл арга, хэмжээний хяналтын тайланг бичсэн байна.

Захиалагчийн хяналтын зардлын хуваарилалтыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 6 №	Санхүүжилт авсан байгууллагын нэр	Хяналт хэрэгжүүлсэн ТАХ-ний тоо	Хүлээн авсан хяналтын зардлын дүн	/мянган төгрөгөөр/ Эзлэх хувь
1	АЗДТГ	7	4,283.8	32.3%
2	ГХБХБГ	7	8,983.1	67.7%
Нийт			13,266.9	100.0%

Хүснэгтээс харахад: Захиалагчийн хяналтын зардлыг 30, 70 хувиар хуваан авах гэрээтэй боловч 32.3, 67.7 хувиар авчээ.

Аудитаар захиалагчийн хяналттай холбоотой баримт материалыг шалгахад аймгийн ЗДТГ нь 7 төсөл 8 арга хэмжээний хяналтын зардлын 32.3% буюу 4,283.8 мянган төгрөгийн хяналтын зардлыг шилжүүлэн авсан боловч захиалагчийн хяналтыг хэрхэн хэрэгжүүлсэн нь тодорхой бус, хяналтын тайлан байхгүй байна.

Гэрээгээр хяналтыг хэрэгжүүлж байгаа ГХБХБГ нь 7 төсөл, арга хэмжээнээс 8,983.1 мянган төгрөгийг шилжүүлэн авсан боловч дараах 3 ажилд хэрхэн хяналт тавьсан нь тодорхойгүй, захиалагчийн хяналтын тайланг үдэж архивлаагүй байна. Тухайлбал: “Илчлэг Шивээ ОНӨААТҮГ-т зуух зөөж тээвэрлэх, суурилуулах ажил”-ын хяналтын зардлын тайланг архивлаагүй, “Цагдаагийн постны авто зогсоолын ажил”, “Чойр хийдийн дуганы гадна, дотор засварын ажил”-уудын ажилд хяналт хийгдээгүй байна.

Эдгээр нь захиалагч болон захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагын уялдаа холбоо хангалтгүй байгаагаас шалтгаалжээ.

Энэ нь захиалагчийн хяналт үр дүнтэй хэрэгжиж чадаагүйг харуулж байгаа бөгөөд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т **“төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”** 14 дүгээр зүйлийн 14.2.3-т **“өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”**, Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.19-д **“барилгын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, фото зургаар баримтжуулан, ил, далд ажлын актыг баталгаажуулах”**, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан **“Барилгын ажлын захиалагчийн дүрэм”**-ийн 3 дугаар зүйлийн 3.4-т **“Захиалагч барилгын ажлын явц, үе шатанд тавих хяналтыг гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч болон барилгын үйл ажиллагаанд оролцогч бусад этгээдтэй хамтран гэрээний үндсэн дээр өдөр, сар, улирал бүрээр гүйцэтгэнэ.”**, 3.9-д **“Захиалагч үе шатны ажилд техникийн хяналт тавих, гүйцэтгэлийн тэмдэглэл, ил далд ажлын болон тоног төхөөрөмжийн угсралт, туршилт, тохируулга хийсэн акт, санхүүжилтийн тооцоо, холбогдох бусад баримт бичгийг барилгын ажил гүйцэтгэх график, гэрээний дагуу барилгын үйл ажиллагаанд оролцогчтой хамтран хянаж, баталгаажуулахаас гадна техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээдтэй хамтарсан үзлэг шалгалтыг урьдчилан сэргийлэх зорилгоор тухай бүр хийсэн байна.”** гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд барилгын ажлын үе шат бүрд хийсэн хяналтын тайланг тухай бүр гаргаж хэвших, захиалагчийн хяналтын гэрээгээр хүлээн үүргээ биелүүлэх, хяналтын зардлыг зөвхөн хяналт хэрэгжүүлсэн байгууллагад олгох зөвлөмжийг аймгийн ЗДТГ болон ГХБХБГ-т өгөхөөр шийдвэрлэв.

2.2.5 ОНХО-аар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт шалгалт хийгдээгүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд мэргэжлийн байгууллагын зүгээс аймгийн ГХБХБГ захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн бөгөөд мэргэжлийн хяналт болон бусад байгууллагуудаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Бүлэг 3

Хөрөнгө оруулалтын үр нөлөөг тооцоогүй, хөрөнгийг ашиглагч байгууллагууд бүртгэж тайлагнаагүй, бүрэн хүчин чадлаар нь ашиглаагүй байна.

3.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын зорилтот түвшнийг урьдчилан тооцоогүйгээс гүйцэтгэл болон хүрсэн үр дүнгийн талаар судалгаа хийгдээгүй, ашиглалтад хүлээн авсан хөрөнгө оруулалтын ажлыг ашиглагч байгууллагууд бүртгэж тайлагнаагүй, түүнд хяналт тавиагүй байна.

3.1.1 Аймаг, орон нутгаас хөрөнгө оруулалтын хүрэх үр дүн зорилтот түвшнийг урьдчилсан байдлаар тооцож, хүрсэн үр дүнтэй харьцуулж судалгаа хийгээгүй байна.

3.1.2 Зарим тоног төхөөрөмжийг ашиглагч байгууллага бүртгэж тайлагнаагүй, бүрэн хүчин чадлаар нь ашиглаагүй байна.

Аудитын явцад улсын комисс ажиллаж ашиглалтад хүлээн авсан хөрөнгийг ашиглагч байгууллагуудын бүртгэл тайлагнал, ашиглалтын байдалд шалгалт хийхэд нийт 944,670.4 мянган төгрөгийн хөрөнгийг аймгийн ИТХТ-дийн 2020 оны 79 дүгээр тогтоолоор данс бүртгэлд тусгахаар шийдвэрлэсэн боловч дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. “Төрийн байгууллагуудад тоног төхөөрөмж авах” ажлыг 100 хувь хүлээлгэн өгсөн боловч Баянтал сумын ЗДТГ, Баянтал сумын Эрүүл мэндийн төв, “Илчлэг-шивээ” ОНӨААТҮГ-т тус бүр 1,820.5 мянган төгрөгийн өртөгтэй 3 компьютерийг данс бүртгэлд тусгаагүй.
2. “Найрамдал хотхоны бохирын өргөх станцын өргөтгөлийн ажил”-ын гүйцэтгэгч “Илчит сансар” ХХК нь 147,832.3 мянган төгрөгийн өртөг бүхий ажлыг 100 хувь ашиглалтад хүлээлгэн өгсөн боловч ашиглагч “Ус-Ду” ОНӨААТҮГ данс бүртгэлдээ тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “Үнэн зөв байх”, 14 дүгээр зүйлийн 14.4.2-т “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Сангийн сайдын 2018 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.26-д “Эцсийн санхүүжилтийг авахад тухайн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглагч байгууллага нь бүртгэлд тусгасныг нотлох баримт үйлдэж баримт бичгийн иж бүрдэлд хавсаргана” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд аймгийн ИТХТ-дийн тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг ашиглагч байгууллагад бүрэн бүртгүүлэх зөвлөмжийг Орон нутгийн өмчийн газарт өгөхөөр шийдвэрлэв.

Гүйцэтгэлийн аудитаар нийт 303,293.8 мянган төгрөгийн 11 алдаа, зөрчил илрүүлж, алдаа зөрчлийг арилгах 150,000.0 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 153,293.8 мянган төгрөгийн 9 зөвлөмж өглөө.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

Бүлэг-1

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтыг орон нутгийн дунд хугацаанд баримтлах бодлогын баримт бичгийг үндэслэн төлөвлөөгүй байна.
2. Зураг төсвийн ажлын даалгаврын 77 хувийг хугацаа алдан боловсруулж он дамжуулснаас магадлалаар баталгаажиж дуусаагүй байна.
3. Төлөвлөлтийн шаардлага хангаагүй болон хөрөнгө оруулалтын бус шинж чанартай төсөл арга хэмжээ батлагдсан байна.

Бүлэг-2

1. Захиалагч зураг төсвийн ажлыг батлагдсан төсөвт өртгөөр нь бус жижиглэж шууд гэрээ байгуулсан нь ил тод байдал, өрсөлдөөнийг хязгаарласан байна.
2. Зарим ажлын гүйцэтгэгч нар ажлыг чанартай хийгээгүй, захиалагчийн хяналт хангалтгүй, мэргэжлийн байгууллагаас хяналт шалгалт хийгээгүй байна.

Бүлэг-3

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын зорилтот түвшнийг урьдчилан тооцоогүйгээс гүйцэтгэл болон хүрсэн үр дүнгийн талаар судалгаа хийгдээгүй, ашиглалтад хүлээн авсан хөрөнгө оруулалтын ажлыг ашиглагч байгууллагууд бүртгэж тайлагнаагүй, түүнд хяналт тавиагүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Үүнд:

Захиалагч буюу аймгийн Засаг даргын тамгын газарт:

1. Аймгийн хэмжээнд хөрөнгө оруулалтаар хийгдэх шаардлагатай ажлын жагсаалтыг гаргаж, ач холбогдлоор нь эрэмбэлж, дунд хугацааны бодлогын бичиг баримтуудтай уялдуулан төсөл, арга хэмжээний үр ашиг, үр нөлөөг тооцож төлөвлөх
2. Аймгийн ИТХ-аар төсөв батлуулахдаа зураг төсвийн жагсаалтыг хамтад нь батлуулах, зураг төсвийн ажлын даалгаврыг тухайн жилийн төсөв батлагдсан даруй боловсруулж, худалдан авах ажиллагааг эхлүүлэх
3. Төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөхгүй байх
4. Хөрөнгө оруулалтын шинж чанаргүй төсөл арга хэмжээг төлөвлөж батлуулахгүй байх
5. Захиалагчийн хяналтын гэрээний биелэлтийг тооцож дүгнэх, хяналтын зардлыг зөвхөн хяналт хэрэгжүүлсэн байгууллагад олгох

Орон нутгийн өмчийн газарт:

1. Үнэлгээний хорооны баримт бичгийг тухай бүр үйлдэж гарын үсгээр баталгаажуулах
2. Тендерийн баримт бичгийг хуульд журамд заасны дагуу иж бүрэн боловсруулах
3. Аймгийн ИТХТ-дийн тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг ашиглагч байгууллагад бүрэн бүртгүүлэх

Газрын харилцаа, барилга хот, байгуулалтын газарт:

1. Барилгын ажлын үе шат бүрд хийсэн хяналтын тайланг тухай бүр гаргаж хэвших, баримтжуулах, нотлох баримтын бүрдлийг хангах, захиалагчийн хяналтын гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэх

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг,
Найрамдал хотхон, Утас/Факс: (976) 7054 3118,
И-мэйл: zdtg.gsa@gmail.com, Вэбсайт: www.govisumber.gov.mn

2021. 05. 31 № 01/688
танай 2021. 05. 27-ны № 157 -г

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

2020 оны орон нутгийн хөрөнгө оруулалтад хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 09 дүгээр тогтоолоор "Аймгийн өвс тэжээлийн аюулгүй нөөц бүрдүүлэх арга хэмжээний зардал"-д 30,0 сая төгрөгийг төлөвлөсөн бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 19 дүгээр тогтоолоор Манай аймгийн аюулгүй фонд байршуулах өвс тэжээлийн хэмжээг 2 дахин ихэсгэж өвс 200 тн, тэжээл 50 тн-ийг бэлтгэхээр заасны дагуу төсвийн тодотголоор өвс тэжээлийн аюулгүй нөөц бүрдүүлэх зардлыг нэмэгдүүлэх шаардлага гарсан.

Үүний дагуу Орон нутгийн хөгжил сангийн зардлыг нэмэгдүүлэх боломжгүй тул Орон нутгийн хөрөнгө оруулалтын зардалд 65,0 сая төгрөгийг нэмж батлуулсан болно.

ДАРГА



4282100845

Б. Дорхандорж
Санаагтэй Ажил-
хан, Төрийн ажил
Төрийн газар
Батлагануулах

2021

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР:

Аймгийн Засаг даргын Тамгын газраас тайлангийн төсөлд өгсөн саналыг хянаж үзээд үндэслэлтэй санал тайлбар ирүүлээгүй тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

2020 онд батлагдсан орон нутгийн хөрөнгө оруулалт нь аймгийн бодлогын баримт бичгүүдэд нийцсэн эсэхийг тулгасан жагсаалт

№	Хуулийн код	Төсөл, арга хэмжээний нэр	Засаг даргын 2016-2020 үйл ажиллагааны хөтөлбөр	Аймгийн Эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл
1	2019.11.29 №09 1.1.2	1,2,4 дүгээр багт хийгдэх тоглоомын талбай, тохижилтын ажил	12.42 Нийтийн эзэмшлийн талбайг тохижуулна.	42.1/ 1,2,3, 4 дүгээр багт хийгдэх тоглоомын талбай, тохижилтын ажил
2	2019.11.29 №09 1.1.3	3 дугаар багийн нийтийн эзэмшлийн талбайн тохижилт /Цэргийн алдрын хөшөө, Сүмбэр гардены хүүхдийн тоглоом/	12.42 Нийтийн эзэмшлийн талбайг тохижуулна.	42.2/ Цэргийн алдрын хөшөөний тохижилт ажил
3	2019.11.29 №09 1.1.4	Найрамдал хотхоны бохирын өргөх станцын өргөтгөлийн ажил	12.41 Хонхор хотхонд ус зайлуулах систем байгуулах, орон сууцны барилгын техникийн давхрыг үйлчиллэл үйлчилгээний зориулалтаар засварлана.	38/ Найрамдал хотхоны бохирын өргөх станцад өргөтгөл хийх
4	2019.11.29 №09 1.1.7	Тохижилтын ажлын хяналтын камер байршуулах ажил	31.115/ Аймгийн төвийн гудамж, талбайг теле хяналтын камерийн систем	43/ "Хоггүй Говьсүмбэр" арга хэмжээг хэрэгжүүлж ажиллан, өмнөх онд хийгдсэн тохижилтын ажлуудад хяналтын камер байршуулна.
5	2019.11.29 №09 1.1.8	Цагдаагийн постны авто зогсоолын ажил	Нийцээгүй	Нийцээгүй
6	2019.11.29 №09 1.1.9	Гомбосүрэн ноёны нэрэмжит талбайн тохижилтын ажил	12.42 Нийтийн эзэмшлийн талбайг тохижуулна.	42.1/ 1,2,3, 4 дүгээр багт хийгдэх тоглоомын талбай, тохижилтын ажил
7	2020.09.18 №17 1.1.1	Илчлэг Шивээ ОНӨААТҮГ-азарт зуух зөөж тээвэрлэх, суурилуулах ажил	Нийцээгүй	Нийцээгүй
8	2020.09.18 №17 1.1.2	Талын Илч ОНӨААТҮГ-азарт зуух худалдан авч суурилуулах ажил	Нийцээгүй	Нийцээгүй
9	2020.09.18 №17 1.1.4	Чойр хийдийн дуганы гадна, дотор засварын ажил	Нийцээгүй	Нийцээгүй
10	2019.11.29 №09 1.2.1	Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ-т хог тээвэрлэх автомашин худалдан авах ажил	Нийцээгүй	Нийцээгүй
11	2019.11.29 №09 1.2.4	Төрийн байгууллагуудад тоног төхөөрөмж худалдан авах	30.113/Төрийн худалдан авалтыг 100 хувь цахим хэлбэрээр зохион байгуулна	101/Төрийн байгууллагуудыг шаардлагатай автомашин, тоног төхөөрөмжөөр хангах
12	2019.11.29 №09 1.2.5	Биеийн тамир спортын газрыг шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах	Нийцээгүй	Нийцээгүй

13	2019.11.29 №09 1.2.6	100 ортой нэгдсэн эмнэлгийн барилгын ажлыг дуусгаж, шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах	17.62/ Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.	57/ 100 ортой нэгдсэн эмнэлгийн барилгын ажлыг дуусгаж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.
14	2019.11.29 №09 1.2.7	Сургууль, цэцэрлэг, номын сангийн фондыг нэмэгдүүлэх зорилгоор ном худалдан авах	Хэрэгжүүлэх хугацаа дууссан	66/ Сургууль, цэцэрлэг, номын сангийн номын фондыг нэмэгдүүлнэ.
15	2019.11.29 №09 1.2.8	Цөм сүрэг үржлийн төвд автомашин худалдан авах	Нийцээгүй	101/Төрийн байгууллагуудыг шаардлагатай автомашин, тоног төхөөрөмжөөр хангах
16	2019.11.29 №09 1.2.11	Аймгийн өвс тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэх арга хэмжээний зардал	Нийцээгүй	16/ Аймгийн өвс тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлнэ.
17	2020.09.18 №17 2.1.3	Боржигин өв соёлыг түгээх, сурталчилахад зориулж эд зүйлс худалдан авах	Нийцээгүй	Нийцээгүй
18	2020.09.18 №17 3.1.1	Аймгийн өвсний нөөц бүрдүүлэх	Нийцээгүй	16/ Аймгийн өвс тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлнэ.
19	2020.09.18 №17 3.1.1	Аймгийн тэжээлийн нөөц бүрдүүлэх	Нийцээгүй	16/ Аймгийн өвс тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлнэ.
20	2020.09.18 №17 2.1.1	Мэргэшсэн эмч нарын байранд эд зүйлс худалдан авах ажил	Нийцээгүй	Нийцээгүй
21	2020.09.18 №17 2.1.2	Усан спорт сургалтын төвийн усан бассейны засварын ажилд шаардлагатай бараа материал худалдан авах ажил	Нийцээгүй	Нийцээгүй
22	2019.11.29 №09 1.2.3	ГХБХБГазарт автомашин худалдан авах ажил	Нийцээгүй	Нийцээгүй
23	2019.11.29 №09 1.2.9	Төрийн архивын хадгалалт, хамгаалалт	30.112/ Архивын баритм, хадгалалт, хамгаалалт сайжирна.	98/ Төрийн архивын хадгалалт, хамгаалалтын нөхцлийг сайжруулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах
24	2019.11.29 №09 1.1.6	Ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байрны засвар	22.82/ Хөгжлийн төвийн үйл ажиллагаа тогтмолжсон	75/ Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байрыг засварлана.
25	2019.11.29 №09 1.2.10	Гацуур мод худалдан авах ажил	Нийцээгүй	Нийцээгүй
26	2019.11.29 №09 1.2.2	Аймгийн Засаг даргын тамгын газарт автомашин худалдан авах ажил	Нийцээгүй	101/Төрийн байгууллагуудыг шаардлагатай автомашин, тоног төхөөрөмжөөр хангах
27	2019.11.29 №09 1.1.5	Баянтал 4-р сургуулийн урлаг заалны их засварын ажлын зураг төсөв	Нийцээгүй	37/ 2021 онд хийгдэх ажлын зураг төсөв боловсруулах ажил
28	2019.11.29 №09 1.1.5	Чойр хийдийн гол Дуганы өөрчлөлтийн зураг төсөв	Нийцээгүй	37/ 2021 онд хийгдэх ажлын зураг төсөв боловсруулах ажил

29	2019.11.29 №09 1.1.5	Сүмбэр сум 2 дугаар багийн тоглоомын талбайн зураг төсөв	Нийцээгүй	37/ 2021 онд хийгдэх ажлын зураг төсөв боловсруулах ажил
30	2019.11.29 №09 1.1.5	Төсөв шинэчлэх	Нийцээгүй	37/ 2021 онд хийгдэх ажлын зураг төсөв боловсруулах ажил
31	2019.11.29 №09 1.1.5	Халдвартын эмнэлгийн их засварын ажлын зураг төсөв	Нийцээгүй	37/ 2021 онд хийгдэх ажлын зураг төсөв боловсруулах ажил
32	2019.11.29 №09 1.1.5	Нийтийн номын сангийн барилгын их засварын зураг төсөв	Нийцээгүй	37/ 2021 онд хийгдэх ажлын зураг төсөв боловсруулах ажил
33	2019.11.29 №09 1.1.5	Боржигин өв музейн барилгын их засварын зураг төсөв	Нийцээгүй	37/ 2021 онд хийгдэх ажлын зураг төсөв боловсруулах ажил
34	2019.11.29 №09 1.1.5	Хүүхдийн эмнэлгийн их засварын зураг төсөв	Нийцээгүй	37/ 2021 онд хийгдэх ажлын зураг төсөв боловсруулах ажил
35	2019.11.29 №09 1.1.5	Сүмбэр сумын 1-р сургуулийн өргөтгөлийн барилга	Нийцээгүй	37/ 2021 онд хийгдэх ажлын зураг төсөв боловсруулах ажил
36	2019.11.29 №09 1.1.5	Аймгийн төвийн гэрэлтүүлгийн ажил	Нийцээгүй	49/Аймгийн төвийн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх
37	2019.11.29 №09 1.1.5	Сүмбэр сум 2 дугаар багийн тоглоомын талбайн зураг төсөв	Нийцээгүй	37/ 2021 онд хийгдэх ажлын зураг төсөв боловсруулах ажил
38	2019.11.29 №09 1.1.6	Сүмбэр сумын 1-р багт дахин төлөвлөлт хэрэгжүүлэх байршилд ерөнхий төлөвлөгөөний зураг	Нийцээгүй	37/ 2021 онд хийгдэх ажлын зураг төсөв боловсруулах ажил